



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Буянт сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2024/100/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

Аудитор: А.Нарандэлгэр

Утас: 86001147 Цахим хаяг: narandelgera@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

2024.02.25 № 1/104  
танай 2024.01.25 -ны № 12 -т

БУЯНТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ЭРХЛЭГЧ ЭМЧ  
Т.ЭНХТУЯА ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн даатгалын сантай тооцоо нийлж авлагыг баталгаажуулсан ч тайланд тусгаагүй байна.

### Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

### Бусад асуудлын хэсэг

Буянт сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 10 зорилтын хүрээнд 63 арга хэмжээг төлөвлөж, 89.4 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>81,796,471.06</b>	<b>190,936,494.96</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>12,194,380.54</b>	<b>56,813,624.08</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	12,194,380.54	56,813,624.08
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	12,194,380.54	56,813,624.08
31211	Төрийн сангийн харилцах	12,194,380.54	56,813,624.08
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>50,000.00</b>	<b>10,069,789.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	50,000.00	187,500.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	9,882,289.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>69,552,090.52</b>	<b>124,053,081.88</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>16,484,098.07</b>	<b>53,575,054.78</b>
35110	Тусгай зориулалттай материал	5,194,440.17	5,641,390.17
35130	Эм боох материал	11,289,657.90	47,933,664.61
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>53,067,992.45</b>	<b>70,478,027.10</b>
35410	Бичиг хэргийн материал	545,400.00	975,640.00
35420	Аж ахуйн материал	47,249,840.00	55,595,911.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	175,000.00
35440	Түлш, шатах тослох материал	675,000.00	3,424,020.00
35460	Хүнсний материал	3,997,752.45	9,553,456.10
35470	Бусад хангамжийн материал	600,000.00	754,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>514,020,608.37</b>	<b>538,648,360.87</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>514,020,608.37</b>	<b>538,648,360.87</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>487,877,795.76</b>	<b>512,642,798.26</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	425,149,286.00	465,129,286.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(57,974,856.95)	(71,921,593.07)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	87,979,720.00	87,979,720.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(37,619,583.11)	(55,690,138.19)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	178,317,029.17	213,877,208.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	(110,563,040.30)	(131,682,989.31)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,997,884.90	18,357,884.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,408,643.95)	(13,406,580.24)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>26,142,812.61</b>	<b>26,005,562.61</b>
39301	Програм хангамж	732,000.00	732,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(589,187.39)	(726,437.39)
39303	Бусад биет бус хөрөнгө	26,000,000.00	26,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>595,817,079.43</b>	<b>729,584,855.83</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>726,000.00</b>	<b>3,910,610.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>726,000.00</b>	<b>3,910,610.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>726,000.00</b>	<b>3,910,610.00</b>
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	726,000.00	3,910,610.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>595,091,079.43</b>	<b>725,674,245.83</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>595,091,079.43</b>	<b>725,674,245.83</b>

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	176,131,310.00	176,131,310.00
51101	Өмч: - төрийн	176,131,310.00	176,131,310.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>170,569,985.35</b>	<b>301,153,151.75</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	170,569,985.35	170,569,985.35
51220	Тайлант үеийн үр дүн	-	130,583,166.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	248,389,784.08	248,389,784.08
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>595,817,079.43</b>	<b>729,584,855.83</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>603,213,224.72</b>	<b>784,509,334.77</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>48,532,832.72</b>	<b>87,883,455.91</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>48,532,832.72</b>	<b>87,883,455.91</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	48,532,832.72	87,510,455.91
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,143,500.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	37,389,332.72	87,510,455.91
120009	Бусад орлого	-	373,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>554,680,392.00</b>	<b>696,625,878.86</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	476.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	476.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>30,220,676.00</b>	<b>22,586,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,220,200.00	22,586,000.00
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	476.00	-
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>524,459,240.00</b>	<b>674,039,878.86</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	524,459,240.00	674,039,878.86
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>591,484,649.97</b>	<b>653,926,168.37</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>591,484,649.97</b>	<b>653,926,168.37</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>588,838,590.97</b>	<b>653,563,685.52</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>368,124,257.46</b>	<b>418,054,578.45</b>
210101	Үндсэн цалин	224,623,612.46	250,045,180.38
210102	Нэмэгдэл	112,402,576.00	107,103,807.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,287,000.00	4,632,005.28
210104	Урамшуулал	26,811,069.00	33,095,809.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	23,177,775.82
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>45,621,007.46</b>	<b>53,171,924.73</b>
210201	Тэтгэврийн даатгал	30,413,102.82	38,162,253.36
210202	Тэтгэмжийн даатгал	3,722,649.40	3,771,259.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,388,967.33	3,017,007.61
210204	Ажилгүйдлийн даатгал	939,632.11	747,400.05
210205	Эрүүл мэндийн даатгал	7,156,655.80	7,474,004.18

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>19,376,290.00</b>	<b>17,980,347.15</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,323,120.00	4,360,137.15
210302	Түлш, халаалт	16,053,170.00	13,370,210.00
210303	Цэвэр, бохир ус	-	250,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>27,874,230.00</b>	<b>25,865,686.14</b>
210401	Бичиг хэрэг	2,567,350.00	2,509,000.00
210402	Тээвэр, шатахуун	20,665,940.00	18,923,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,137,000.00	2,479,307.14
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,383,940.00	1,834,379.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>70,376,447.25</b>	<b>74,723,233.55</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	62,957,481.80	64,212,449.20
210502	Хоол, хүнс	7,418,965.45	10,510,784.35
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,760,350.00</b>	<b>2,253,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,938,000.00	1,927,500.00
210604	Урсгал засвар	1,822,350.00	325,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>746,000.00</b>	<b>1,192,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	746,000.00	1,192,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,806,287.54</b>	<b>5,384,015.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,773,287.54	5,209,530.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	141,485.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>45,153,721.26</b>	<b>54,938,900.50</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,043,500.00	666,474.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,110,221.26	54,272,426.50
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,646,059.00</b>	<b>362,482.85</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>2,646,059.00</b>	<b>362,482.85</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,646,059.00	362,482.85
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>11,728,574.75</b>	<b>130,583,166.40</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>11,728,574.75</b>	<b>130,583,166.40</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	176,131,310.00	248,389,784.08	158,842,362.60	583,363,456.68
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>176,131,310.00</b>	<b>248,389,784.08</b>	<b>158,842,362.60</b>	583,363,456.68
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	11,727,622.75	11,727,622.75
C08	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>176,131,310.00</b>	<b>248,389,784.08</b>	<b>170,569,985.35</b>	595,091,079.43

D01	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>176,131,310.00</b>	<b>248,389,784.08</b>	<b>170,569,985.35</b>	595,091,079.43
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>176,131,310.00</b>	<b>248,389,784.08</b>	<b>170,569,985.35</b>	<b>595,091,079.43</b>
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	130,583,166.40	130,583,166.40
D09	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>176,131,310.00</b>	<b>248,389,784.08</b>	<b>301,153,151.75</b>	725,674,245.83

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>593,760,892.00</b>	<b>687,116,589.86</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>11,143,500.00</b>	<b>373,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	11,143,500.00	373,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	11,143,500.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,143,500.00	-
120009	Бусад орлого	-	373,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>582,617,392.00</b>	<b>686,743,589.86</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	476.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	476.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	30,220,676.00	22,586,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,220,200.00	22,586,000.00
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	476.00	-
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	552,396,240.00	664,157,589.86
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	552,396,240.00	664,157,589.86
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>584,212,570.46</b>	<b>642,497,346.32</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>584,212,570.46</b>	<b>642,497,346.32</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>578,919,976.46</b>	<b>642,134,863.47</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	374,378,087.46	421,595,968.43
210101	Үндсэн цалин	230,877,442.46	240,110,244.91
210102	Нэмэгдэл	112,402,576.00	117,507,809.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,287,000.00	5,161,361.35
210104	Урамшуулал	26,811,069.00	40,419,078.48
210105	Гэрээт ажлын хөлс	-	18,397,474.47
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	45,511,219.00	49,690,375.75
210201	Тэтгэврийн даатгал	32,036,084.73	33,840,705.49
210202	Тэтгэмжийн даатгал	3,384,751.98	3,981,259.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,690,841.58	3,437,007.46
210204	Ажилгүйдлийн даатгал	671,936.68	789,400.05
210205	Эрүүл мэндийн даатгал	6,727,604.03	7,642,003.22
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,384,900.00	20,393,567.15

210301	Гэрэл, цахилгаан	2,913,500.00	3,575,454.19
210302	Түлш, халаалт	16,471,400.00	16,818,112.96
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>27,501,240.00</b>	<b>27,044,107.14</b>
210401	Бичиг хэрэг	1,533,050.00	2,076,000.00
210402	Тээвэр, шатахуун	20,894,440.00	19,073,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,273,600.00	2,479,307.14
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,015,100.00	1,905,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	785,050.00	1,510,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>86,443,948.00</b>	<b>97,299,588.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	69,954,848.00	80,802,100.00
210502	Хоол, хүнс	8,734,600.00	15,997,488.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,754,500.00	500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>17,698,382.00</b>	<b>6,844,650.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,680,000.00	4,981,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	365,782.00	33,000.00
210604	Урсгал засвар	4,652,600.00	1,829,950.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>746,000.00</b>	<b>1,192,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	746,000.00	1,192,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>978,000.00</b>	<b>3,850,415.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	945,000.00	3,675,930.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	58,485.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	83,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,278,200.00</b>	<b>14,224,192.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,278,200.00	14,224,192.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,292,594.00</b>	<b>362,482.85</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>476.00</b>	<b>-</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	476.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>5,292,118.00</b>	<b>362,482.85</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,292,118.00	362,482.85
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>9,548,321.54</b>	<b>44,619,243.54</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>9,548,321.54</b>	<b>44,619,243.54</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>12,194,380.54</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>12,194,380.54</b>	<b>56,813,624.08</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>743,590,900.00</b>	<b>642,134,863.47</b>

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	743,590,900.00	642,134,863.47
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	742,590,900.00	642,134,863.47
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	496,914,600.00	421,595,968.43
210101	Үндсэн цалин	305,128,200.00	240,110,244.91
210102	Нэмэгдэл	157,093,100.00	117,507,809.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,392,000.00	5,161,361.35
210104	Урамшуулал	27,301,300.00	40,419,078.48
210105	Гэрээт ажлын хөлс	-	18,397,474.47
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	62,114,900.00	49,690,375.75
210201	Тэтгэврийн даатгал	42,237,800.00	33,840,705.49
210202	Тэтгэмжийн даатгал	4,968,900.00	3,981,259.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,975,400.00	3,437,007.46
210204	Ажилгүйдлийн даатгал	994,200.00	789,400.05
210205	Эрүүл мэндийн даатгал	9,938,600.00	7,642,003.22
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,733,900.00	20,393,567.15
210301	Гэрэл, цахилгаан	3,787,500.00	3,575,454.19
210302	Түлш, халаалт	16,500,000.00	16,818,112.96
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	32,228,700.00	27,044,107.14
210401	Бичиг хэрэг	3,300,300.00	2,076,000.00
210402	Тээвэр, шатахуун	21,228,700.00	19,073,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,199,700.00	2,479,307.14
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,250,000.00	1,905,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,250,000.00	1,510,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	97,540,800.00	97,444,838.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	80,802,100.00	80,947,350.00
210502	Хоол, хүнс	16,238,700.00	15,997,488.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,102,100.00	6,844,650.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	4,981,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,250,000.00	33,000.00
210604	Урсгал засвар	1,852,100.00	1,829,950.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,800,000.00	1,192,000.00
210702	Дотоод албан томилолт	1,800,000.00	1,192,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	7,309,700.00	3,850,415.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,500,000.00	3,675,930.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	58,485.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	83,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	90,000.00	33,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	15,846,200.00	14,078,942.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,846,200.00	14,078,942.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	743,590,900.00	686,754,107.01
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	22,586,000.00	22,223,517.15
132001	Орон нутгийн төсвөөс	22,586,000.00	22,223,517.15
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	708,810,519.46	664,157,589.86

134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	708,810,519.46	664,157,589.86
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	12,194,380.54	373,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		373,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	12,194,380.54	
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>12,194,380.54</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>56,813,624.08</b>

### 3 . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар нийт 18,141.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 9,882.3 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Аудитаар нийт 9,882.3 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн авлагыг бүртгээгүй

Залруулагдаагүй нийт 8,258.7 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 8,258.7 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 2,478.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 5,780.2 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмжийг өглөө.

#### 3.1 Төлбөрийн акт

1. Албан хаагчдад 2-р улирлын үр дүнгийн урамшууллыг зөрүүтэй тооцож олгосон нийт 2,478.5 мянган төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.3-д “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

#### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Бараа материалын данстай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Эмийн тооллогыг үр дүнтэй хийгээгүй, тооллогын дүнг нэгтгэж бодоогүй, Тусгай зөвшөөрөл аваагүй Ариун гантиг ХХК-аас эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-д “Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага”, 9.2-д “Энэ хуулийн 9.1-д заасан эм хангамжийн байгууллагын эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрөл авахаас бусад эм хангамжийн байгууллагатай холбогдсон харилцааг Эрүүл мэндийн тухай хуулиар зохицуулна”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2-д “түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Эмийн тооллогыг улирал бүр хийж, тооллогын дүнг нэгтгэн, холбогдох баримт материалыг санхүүд бүрэн бүрдүүлж өгөх, Ариун гантиг ХХК-аас оношлуур худалдан авахгүй байх

## **2. Үндсэн хөрөнгө данстай холбоотой асуудал**

### **Илрүүлэлт:**

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.10-д "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 3,039.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг зөв ангилан бүртгэх

## **3. Зардлын данстай холбоотой асуудал**

### **Илрүүлэлт:**

Эрхлэгч эмч Т.Энхтуяад олгох зэргийн нэмэгдлийг 10,11 саруудад дутуу олгосон, Хүний нөөцийн программд албан хаагчдын ажилласан жилийн мэдээллийг бүрэн оруулаагүй, ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг цалингийн зөрүү дээр оруулсан зэрэг зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.3-д "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэсэн заалт" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрхлэгч эмч Т.Энхтуяад дутуу олгосон 337.4 мянган төгрөгийн зэргийн нэмэгдлийг нөхөн олгох, Хүний нөөцийн программд албан хаагчдын мэдээллийг үнэн зөв оруулах.

## **4. Газартай холбоотой асуудал**

### **Илрүүлэлт:**

Байгууллагын эзэмшилд байгаа газрын санхүүгийн тайлангийн тайланд тусгагдсан хэмжээ газрын гэрчилгээний дүнтэй зөрсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын эзэмшилд байгаа газрын гэрчилгээг шинэчлэхдээ газрын хэмжээг Буянт сумын Засаг даргын 2022 оны 06 сарын 23-ны өдрийн А/107 дугаарын захирамжаар өөрчлөн 6942 м2 болгосон байх тул холбогдох арга хэмжээг авч, санхүүгийн тайланд тоо хэмжээг зөв тусган тайлагнах.

## **5. Шилэн данстай холбоотой асуудал**

### **Илрүүлэлт:**

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллээс хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.5, 6.4.8 заасныг түүвэрлэн авч үзэхэд нийт 159 мэдээлэл байршуулахаас цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зардлын 21,264.5 мянган төгрөгийн 3 гүйлгээ, орлогын 103,951.8 мянган төгрөгийн 5 гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” 7 дугаар зүйлийн 7.1-д “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ”, 7.1.3-д “тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж ажиллах.

#### 4.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Буянт сумын Эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн авлагыг бүртгээгүй	1	9,882.3	1	9,882.3			1	9,882.3				
<b>ДҮН</b>		<b>1</b>	<b>9,882.3</b>	<b>1</b>	<b>9,882.3</b>			<b>1</b>	<b>9,882.3</b>				

##### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Зөрчлийн төрөл							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	3	4	5	6	7	8	9	10	11	12
Буянт сумын эрүүл мэндийн төв	1	2,478.5	1	2,478.5						
	1	2,403.0					1.0	2,403.0		
	1	3,039.8					1	3,039.8		
	1	337.4					1	337.4		
	1	-					1	-		
	1	-					1	-		
<b>Нийт</b>	<b>6</b>	<b>8,258.7</b>	<b>1</b>	<b>2,478.5</b>			<b>5</b>	<b>5,780.2</b>		

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	-	1	-	-	1	-	-	-
НИЙТ			1	-	-	1	-	-	-

